



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/06

Залаа

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, “Газрын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газарт өгсөн чиглэлийн хүрээнд “Монгол Улсын газрын нэгдмэл сан, газар эзэмшил ашиглалтын бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажил”-ын дагуу иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудлыг шалгах, ажлын хэсэгт хяналт шалгалтаар хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан ажлын бэлтгэлийг хангаж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батхуяг

(Тамгын газрын дарга)

Гишүүд:

Ш.Бямбацогоо

(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Д.Энхдалай

(Зараа багийн Засаг дарга)

М.Болдцэрэн

(Уртын гол багийн Засаг дарга)

Б.Ангирмаа

(Эрдэнэшанд багийн Засаг дарга)

Б.Энхтулга

(Эхэнхавцгай багийн Засаг дарга)

Б.Оюунгэрэл

(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Э.Золжаргал

(Хурлын ажилтан)

642301147

Нарийн бичгийн дарга: У.Мөнхнаран
(Газрын даамал)

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж Монгол Улсын газрын нэгдмэл сан, газар эзэмшил ашиглалтын бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын бэлтгэл ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батхуяг)-д даалгасугай.

ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ